



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/306

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Хэрлэн суманд коронавирусын цар тахлын тохиолдол илэрсэнтэй холбогдуулан коронавирусын цар тахлын голомтод ажилласан Нэгдсэн эмнэлгийн 9 ажилтныг 5 дугаар сарын 22-ноос 5 дугаар сарын 27, 6 дугаар сарын 11-нээс 6 дугаар сарын 17 хүртэлх өдрүүдэд нийт 2 удаа тусгаарлах байранд байрлуулсан зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 4,441,000 (дөрвөн сая дөрвөн зуун дөчин нэгэн мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансны хандивын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ